



# МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1995 оны 12 дугаар сарын 15 өдөр

Дугаар А/273

Улаанбаатар хот

"Дөрвөн уул" радиогийн талаар авах арга хэмжээний тухай

1. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 1995 оны 63 дугаар тогтоолыг үндэслэн "Дөрвөн уул" радиогийн дүрмийг хавсралт ёсоор баталсугай.
2. "Дөрвөн уул" радиод ажлын байр гарган огч, мэргэжлийн боловсон хүчнээр бэхжүүлэх, монголын радио телевизийн хэрэг эрхлэх газартай радиогийн сувгийн асуудлаар гэрээ байгуулж ажиллахыг Тамгын газрын дарга Ц. Болдсайхан-д даалгасугай.
3. "Дөрвөн уул" радиод шаардагдах техник, тоног төхөөрөмж авах, студи тоноглоход зориулж 48,0 сая төгрөгийг 1995 оны төсвийн орлогын төлөвлөгөөний давалтаас олгон, 18 нэгж орон тоогоор ажиллуулах цалин, зардлыг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлэхийг Тамгын газрын Санхүүгийн хэлтэс Ц. Гонгор-т зөвшөөрсүгэй.
4. "Дөрвөн уул" радиогийн даргаар С. Лхагвасүрэнг томилсугай.
5. Нийслэлийн засаг даргын 1995 оны А/30 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 2-ын 1-ын 10-т "Радиогийн Дөрвөн уул редакци" гэснийг "Дөрвөн уул радио" гэж өөрчлөн найруулсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТНЫН ЗАХИРАГЧ

У. БААСАНЖАВ



Нийслэлийн Засаг даргын 1985 оны  
захирамжийн ... тоот  
хаворалт

"Дөрвөн уул" радиогийн дүрэм

Нэг. Ерөнхий зүйл

1. "Дөрвөн уул" радио нь монгол улсын нийслэл хотын төр, захиргааны бодлого шийдвэрийг нийтлэл нэвтрүүлэгтээ тусган хэрэгжүүлэх үүрэг бүхий нийслэлийн Засаг даргын харъяа төрийн өмчийн байгууллага мөн.

Улаанбаатар хотын радио нь нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын ажлын хүрээнд багтана.

2. Улаанбаатар хотын радиогийн зорилт нь нийслэлийн төр захиргааны бодлого шийдвэрийг олон түмэнд үнэн зөв, шуурхай түгээж хүргэх, нийгэм эдийн засаг соёл үйлчилгээний олон талт амьдрал, иргэдийн санал бодлыг тусгаж, төр, ард түмнийг холбож ажиллахад оршино.

3. "Дөрвөн уул" радиогийн даргыг нийслэлийн Засаг даргын захирамжаар батална.

4. Нийслэлийн Засаг даргаас Улаанбаатар хотын радиогийн бүтэц зохион байгуулалтыг тогтоож, орон тоо, цалингийн санг батална.

5. "Дөрвөн уул" (хойшид "радио" гэх) радиогийн дарга нь нийслэлийн радиогийн зорилтыг ханган биелүүлэх ажлыг нийслэлийн төр, захиргааны өмнө хариуцаж, эрх хэмжээний асуудлаар Монголын улсын төрийн хууль тогтоомжинд нийцүүлэн тушаал гаргана.

6. Радиогийн дарга нь байгууллагынхаа доторхи нэгж, ажиллагчдын ажил үүргийн хуваарийг баталж мөрдүүлнэ.

7. Радио нь үүрэг зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж байх үүрэг бүхий техник уран сайхны зөвлөлтэй байна. Зөвлөлийг дарга удирдаж, бүрэлдэхүүн дүрмийг батална.

8. Радио нь хууль тогтоомжийн дагуу тамга, тэмдэг, албан бичгийн хөвлэмөл хуудас хэрэглэнэ.

Хоёр. РАДИОГИЙН ҮҮРЭГ

Нийтлэл нэвтрүүлгийн үр хийц чанарыг цаг үеийн мэдрэмжээр байнга баяжуулан үр нөлөөг сайжруулах

-Радиогийн техникийн бодлогыг бэлтгэж хэрэгжүүлэх,  
-Радиогийн шилдэг уран бүтээл, мэдээллийн сан байгуулж арвижуулж ажиллах,

- Ажиллагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авах
- Радиогийн нийтлэл нэвтрүүлэг үйлдвэрлэлтэй холбоотой норм-норматив, үнэ тарифийг боловсруулж нийслэлийн үнийн зөвшлийн комисст бүртгүүлж ажиллах зэрэг үүрэгтэй.

Гурав. "Дөрвөн уул" радиогийн эрх

- Монгол улсын нийслэлийн аль ч байгууллагад сурвалжлага хийх
- Нэвтрүүлэг бэлтгэхэд шаардлагатай баримт мэдээллийг хол-богдох байгууллагаас гаргуулж авах
- Гадаад орны хот нийслэлд өөрийн төлөөлөгчдийн газрыг ажил-луулах асуудлыг төсөвтөө багтаан шийдвэрлэх,
- Гадаад орнуудад сурвалжлах хэсэг, сурвалжлагчийг тодорхой хугацаагаар томилон ажиллуулах
- Гадаад орны хот нийслэл болон олон улсын холбогдох байгуул-лагатай зохих журмын дагуу харилцаа тогтоож хамтран ажиллах
- Бүтэцийнхээ дотоодод аж ахуйн тооцоотой жижиг үйлдвэр, туслалх аж ахуй, үйлчилгээний цэг зохион байгуулж ажиллуулах зэрэг эрхтэй.